



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/34/25

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хүний нөөцийг дэмжих сангийн тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.



Б.ЗОЛБАДРАЛ

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо (НЭЗХЭ)-ны
Удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 17-ны
өдрийн хурлын А/34/25 дугаар тогтоолын хавсралт

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НЭЗХЭ-ИЙН ДЭРГЭДЭХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ДЭМЖИХ САН (ДАНС)-ЫН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн дэргэдэх “Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг дэмжих сан” (цаашид “Сан” гэх) -ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2 Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн дүрэм, холбогдох бусад журмыг баримтална.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

- 2.1 Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн холбогдох чиг үүргийн хороо, ажлын алба хариуцан удирдана.
- 2.2 Сангийн зориулалт нь аялал жуулчлалын салбарын ирээдүйн хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэргүүлэх чиглэлийн суурь судалгаа гүйцэтгэх, тэтгэлэг, грантыг хэрэгжүүлэхэд зарцуулна.
- 2.3 Энэ журмын 2.2-т заасан үйл ажиллагааг санхүүжүүлэх шийдвэрийг холбогдох чиг үүргийн хороо гаргана.
- 2.4 Энэ журмын 2.3-т заасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг ажлын алба хариуцна.

Гурав. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

- 3.1 Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн удирдах зөвлөлийн шийдвэрээр санг байгуулан, данс нээж, хөрөнгийг бүрдүүлнэ.
- 3.2 Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 3.2.1 Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гишүүдийн төлсөн татварын 5 хувиар тооцон татан төвлөрүүлсэн хөрөнгө
 - 3.2.2 Хандив, тусламж
 - 3.2.3 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр
- 3.3 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах хэлбэрээр санхүүжүүлнэ:
 - 3.3.1 буцалтгүй тэтгэлэг
 - 3.3.2 бүрэн хэмжээний санхүүжилт
 - 3.3.3 тодорхой хувийн санхүүжүүлт
- 3.4 Сангийн хөрөнгийг энэ журмын 2.2-т заасны дагуу дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:

- 3.4.1 Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны нэрэмжит “Шилдэг оюутны тэтгэлэг” олгох
- 3.4.2 аялал жуулчлалын салбарын тэргүүлэх чиглэлийн суурь судалгаа гүйцэтгэх
- 3.4.3 тэтгэлэг, грант олгох
- 3.4.4 аялал жуулчлалын судлал, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих
- 3.5 Энэ журмын 3.3-т заасан санхүүжилтийн хэмжээ, хугацаа, хэлбэрийг хэрэгжүүлэгч, оролцогч талуудтай байгуулсан гэрээнд тусгана.
- 3.6 Сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал олгох, батлагдсан төсвөөс хэтрүүлэх, энэ журмын 2.2-т зааснаас бусад үйл ажиллагаа, өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

- 4.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад АЖМХ-ны Хяналтын зөвлөл хяналт тавьж ажиллана.
- 4.2. Сангийн гүйцэтгэсэн үйл ажиллагааны үр дүн, төсвийн зарцуулалтын нэгдсэн тайланг холбогдох дүрэм, журмын дагуу Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны удирдах зөвлөлд хүргүүлнэ.
- 4.3. Сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гишүүд, салбарынханд нээлттэй байна.

